

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Засаг дарга ерөнхий дансны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХӨА-2026/119/НА-СТА-ТЗШ

<p>Цахим хуудас: www.audit.mn Мөрөн сум 2026 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Б.Давааням Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/95
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Засаг дарга ерөнхий дансны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 448,551.1 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 10,710.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч, 1 зөрчилд зөвлөмж хүргүүлж, аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

Засаг дарга ерөнхий дансны дотоод хяналтыг аймгийн ЗДТГ-ын дотоод хяналтын нэгж гүйцэтгэх чиг үүрэгтэй бөгөөд тайлант онд Засаг дарга дансанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Эхний үлдэгдэл	2. Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	448,551,084.0	-
35	БАРАА МАТЕРИАЛ	448,551,084.0	-
35400	Хангамжийн материал	448,551,084.0	-
35470	Бусад хангамжийн материал	448,551,084.0	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	448,551,084.0	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	448,551,084.0	-
51	Засгийн газрын хувь оролцоо	448,551,084.0	448,551,084.0
51200	Хуримтлагдсан үр дүн	448,551,084.0	-
51210	Тайлант үеийн үр дүн		-448,551,084.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	448,551,084.0	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,984,199,000.0	2,941,515,600.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,941,515,600.0
122	Тусламжийн орлого	-	2,941,515,600.0
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,941,515,600.0
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,941,515,600.0
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	2,941,515,600.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,984,199,000.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,984,199,000.0	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,984,199,000.0	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,792,866,800.0	2,941,515,600.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,126,393,518.0	2,380,869,533.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	867,599,256.0	1,249,714,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	803,132,256.0	795,817,700.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	803,132,256.0	795,817,700.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,467,000.0	453,897,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,467,000.0	453,897,000.0
212	ТАТААС	504,023,300.0	500,082,900.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	302,932,800.0	274,000,000.0
212101	Бусад төрийн өмчит байгууллагад олгох татаас	302,932,800.0	274,000,000.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	201,090,500.0	226,082,900.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	201,090,500.0	226,082,900.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	754,770,962.0	631,071,933.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	754,770,962.0	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	754,770,962.0	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	631,071,933.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	631,071,933.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,666,473,282.0	560,646,067.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1,666,473,282.0	560,646,067.0
221001	Их засвар	1,666,473,282.0	560,646,067.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	191,332,200.0	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	191,332,200.0	(448,551,084.0)
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал		
230001	Эргэж төлөгдөх зээл	191,332,200.0	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(191,332,200.0)	(448,551,084.0)

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	-	(448,551,084.0)
-----------	---	---	-----------------

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,984,199,000.0	2,951,515,600.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,951,515,600.0
120	Нийтлэг татварын бус орлого	-	58,000,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	58,000,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	10,000,000.0
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	-	48,000,000.0
122	Тусламжийн орлого	-	2,893,515,600.0
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,893,515,600.0
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,262,443,667.0
122111	Урсгал санхүүжилтийн орлого\	-	2,262,443,667.0
12212	Харъяа төсвийн байгууллагаас төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн орлого	-	631,071,933.0
122121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн орлого\	-	631,071,933.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,984,199,000.0	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	3,984,199,000.0	-
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	3,984,199,000.0	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,126,393,518.0	2,390,869,533.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,126,393,518.0	2,390,869,533.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	867,599,256.0	1,259,714,700.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	803,132,256.0	795,817,700.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	803,132,256.0	795,817,700.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,467,000.0	463,897,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,467,000.0	463,897,000.0
212	ТАТААС	504,023,300.0	500,082,900.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	302,932,800.0	274,000,000.0
212101	Бусад төрийн өмчит байгууллагад олгох татаас	302,932,800.0	274,000,000.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	201,090,500.0	226,082,900.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	201,090,500.0	226,082,900.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	754,770,962.0	631,071,933.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	754,770,962.0	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	754,770,962.0	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	631,071,933.0
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	631,071,933.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,857,805,482.0	560,646,067.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	1,666,473,282.0	560,646,067.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,666,473,282.0	560,646,067.0
2200	Дотоод эх үүсвэрээр	1,666,473,282.0	560,646,067.0
223001	Бусад хөрөнгө	1,666,473,282.0	560,646,067.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(1,666,473,282.0)	(560,646,067.0)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	191,332,200.0	-
230001	Эргэж төлөгдөх зээл	191,332,200.0	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(191,332,200.0)	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,551,084.0			448,551,084.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,551,084.0			448,551,084.0
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,551,084.0	-	-	448,551,084.0
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	448,551,084.0			448,551,084.0
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(448,551,084.0)	(448,551,084.0)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	448,551,084.0	-	(448,551,084.0)	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	3,015,382,400.0	2,272,443,667.0	742,938,733.0	75.4
12	Татварын бус орлого	3,015,382,400.0	2,272,443,667.0	742,938,733.0	75.4
120	Нийтлэг татварын бус орлого	10,000,000.0	10,000,000.0	-	100.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	10,000,000.0	10,000,000.0	-	100.0
122	Тусламжийн орлого	3,005,382,400.0	2,262,443,667.0	742,938,733.0	75.3
122005	Төсвөөс санхүүжих	3,005,382,400.0	2,262,443,667.0	742,938,733.0	75.3
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,063,382,400.0	1,689,371,734.0	1,374,010,666.0	55.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,891,664,400.0	1,128,725,667.0	762,938,733.0	59.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,391,581,500.0	1,259,714,700.0	131,866,800.0	90.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	867,417,700.0	795,817,700.0	71,600,000.0	91.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	867,417,700.0	795,817,700.0	71,600,000.0	91.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	524,163,800.0	463,897,000.0	60,266,800.0	88.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	524,163,800.0	463,897,000.0	60,266,800.0	88.5
212	ТАТААС	500,082,900.0	500,082,900.0	-	100.0
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	274,000,000.0	274,000,000.0	-	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	274,000,000.0	274,000,000.0	-	100.0
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	226,082,900.0	226,082,900.0	-	100.0
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	226,082,900.0	226,082,900.0	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	(631,071,933.0)	631,071,933.0	
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	(631,071,933.0)	631,071,933.0	
213103	Төсвийн санхүүжилт	-	(631,071,933.0)	631,071,933.0	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,171,718,000.0	560,646,067.0	611,071,933.0	47.8
223001	Бусад хөрөнгө	1,171,718,000.0	560,646,067.0	611,071,933.0	47.8
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(48,000,000.0)	583,071,933.0	(631,071,933.0)	(1,214.7)
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	48,000,000.0	(583,071,933.0)	631,071,933.0	(1,214.7)

7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	48,000,000.0	(583,071,933.0)	631,071,933.0	(1,214.7)
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	2.0	2.0	-	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0	1.0	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	2.0	2.0	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.0	1.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	1.0	1.0	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан			-	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,089,623.1 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснээс аудитын явцад тус 3 алдааг залруулсан.

Залруулсан алдаа:

1. Засаг дарга дансны санхүүгийн байдлын тайлангийн бусад хангамжийн материал дансанд 2020 оноос хойш бүртгэлтэй "Хот тохижилт үйлчилгээний төв"-ийн дансанд бүртгэлтэй 448,551.1 мянган төгрөгийн зам засварын ажил бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө." гэж заасныг зөрчсөн, Оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Дэлгэрмөрөн сум дундын ойн ангийн өөрийн орлогыг Засаг дарга дансны өөрийн орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө." гэж заасныг зөрчсөн, Тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн тохиргоо хийгээгүй, орлого зардлын тэнцлийг хангаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт "Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруэл сууриар бүртгэж, тайлагнана" гэж заасныг зөрчсөн, тасалбар болголт батламж мэдлэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 10,710.0 мянган төгрөгийн 2 зөрчил илэрч, 1 зөрчилд зөвлөмж хүргүүлж, аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Аудитаар илэрсэн материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлаас 43,103.8 мянган төгрөгөөр бага тул "**Өөрчлөлтгүй**" дүгнэлт хүргүүлсэн.

5.1 Зөвлөмж

Илрүүлэлт: Засаг дарга дансны 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар тогтоосон 10,710.0 мянган төгрөгийн төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулаагүй, уг зөрчлийг арилгуулахаар завсрын аудитаар хугацаатай зөвлөмж хүргүүлсэнийг биелүүлээгүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4-т "төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх", 16.1.6-д "хуульд заасан бусад үүрэг" гэж заасныг тус тус зөрчсөн, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Цаашид Төсвийн тухай хуульд заасан цаглаварт хугацаанд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэн ирүүлж хэвших.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилжсэн хөрөнгийг данснаас хасаагүй	1	448,551.1			1	448,551.1	1	448,551.1		
Өөрийн орлого биш байхад хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.0		
Төсвийн гүйцэтгэлийн тохиргоо хийгээгүй	1	631,072.0			1	631,072.0	1	631,072.0		
Дүн	3	1,089,623.1			3	1,089,623.1	3	1,089,623.1		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй	1	-					1	-				
Аудитын шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй.	1	10,710.0									1	10,710.0
Дүн	2	10,710.0					1	-			1	10,710.0